

СОЁМБО МЭДЭЭ

ЗАСГИЙН ГАЗАР

БЯМБА ГАРАГААС БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖИНЭ



Засгийн газар ээлжит бусаар хуралдан өчигдөр болж 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 4 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цаг хүртэл улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэхээр боллоо. Нийслэлийн хэмжээнд халдварын тархалтын улаан түвшин тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих, зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт даалгав.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд голомтыг хумьж тархалтыг хязгаарлахыг зорин. Хатуу хөл хорио тогтоохгүй бол 4 дүгээр сарын дунд үед өдөрт 1000 хүн халдварт өртөж, 20 гаруй хүн нас барна гэсэн тооцооллыг тархвар судлаачид гаргасан байна. Иймээс эрсдэлийг хоёроос гурав дахин бууруулахын тулд Засгийн газар дээрх шийдвэрийг гаргалаа.

Дээрх хугацаанд иргэд гэрийн ойролцоох дэлгүүрээс хүнс, түлш, зөөврийн ус, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, эмийн сангаар үйлчлүүлэх, буяны ажилд оролцох, газар тариалан эрхлэх, шинжилгээ өгөх болон дархлаажуулалтад хамрагдах, хязгаарлалттай тоо /нэг дор таваас ихгүй

Засгийн газар уриаллаа.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэн бүрт 300 мянган төгрөгийг дэмжлэг болгож өнөөдөрөөс дансанд нь шилжүүлж эхлэхээр шийдвэрлэв. Шаардагдах хөрөнгийг Оюутолгой компанийн төлсөн татварын өр болох нэг их наяд гаруй төгрөгөөс гаргах юм.

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс 2021 оны 5 дугаар сарын 1-ний дотор нийслэлийн насанд хүрсэн бүх хүнийг вакцины эхний тунд, 50-иас доошгүй хувийг хоёрдахь тунд хамруулах юм.

ВАКЦИНД ХАМРАГДСАН ТУХАЙ МЭДЭЭЛЛЭЭ E-MONGOLIA СИСТЕМЭЭС АВЧ БОЛНО

Иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчлүүлэгч, хэрэглэгчийнхээ вакцин хийлгэсэн эсэх тухай мэдээллийг E-Mongolia цахим хуудаснаас авч болно. Иргэд өөрийн хийлгэсэн вакцины нэр, үйлдвэрлэсэн улс, дархлаажуулалтад хаана, хэзээ хамрагдсан мэдээллээ авах боломжтой.

Аж ахуйн нэгж, байгууллагууд тухайн үйлчлүүлэгч, хэрэглэгч хэдэн тун вакцин тариулсан, баталгаажсан эсэхийг шалгаж болно. Мөн вакцины гэрчилгээг лавлагаа хэлбэрээр монгол, англи хэлээр

ҮЙЛ ЯВДАЛ

"ЦЭРГИЙН НЭГ ӨДӨР" НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Төр, цэргийн нэрт зүтгэлтэн, Батлан хамгаалахын сайд, хурандаа генерал Ж.Ёндон агсны нэрэмжит Цэргийн гавьяаны болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хугацаат цэргийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг эцэг, эхчүүдэд нь сурталчлан таниулах үүднээс "Цэргийн нэг өдөр" нээлттэй хаалганы өдөрлөгийг өчигдөр зохион байгууллаа.

Тус өдөрлөгийн зорилго нь Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний зорилго, зорилт, ангийн үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалт, сэтгэл зүйн бэлтгэл, өдөр тутмын үйл ажиллагаа хэрхэн явагдаж буй байдал, тэдний алба хаах орчин нөхцлийг танилцуулахад чиглэгдсэн юм.

Өдөрлөгийн эхэнд ангийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн товч танилцуулгыг хийж, өдөр тутмын цагийн хуваарьт үйл ажиллагааг харуулсан видео бичлэгийг үзүүлэв. Энэ

газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг "Өнгөрсөн оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Зэвсэгт хүчний 032 дугаар анги дээр хугацаат цэргийн алба хаагчид татагдан ирсэн. Эдгээр цэргүүд маань нэг жилийн хугацааг ардаа үдэж ирэх сарын нэгэн гэхэд халагдана. Цэрэг халагдах мөчид албаа хэрхэн хааж, юу сурч мэдсэн талаараа ард иргэдэд сурталчлан таниулах үүднээс сурталчилгааны ажлыг тогтмол зохион явуулдаг. Харин өнөөдөр хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөллийг урьж цэргүүдийн алба хаах орчин нөхцөл, өдөр тутмын үйл ажиллагаа хэрхэн явагддаг талаар болон тус ангиас төрөн гарсан ахмад дайчид, алдартнуудын намтартай танилцуулах зорилго дор энэхүү нээлттэй хаалганы өдөрлөг болж байна" гэж хэлээд Монгол Улсын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, хугацаат цэргийн алба хаагчдын онцлог чанар, түүхэн ойгоор төлөвлөсөн ажил, арга хэмжээнүүд болон батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэлийн талаар мэдээллийг өгсөн юм.



үеэр тэрээр "Бид жил бүр хугацаат цэргийн алба хаагчдаа халагдахаас нь өмнө ар гэрийнхэнд нь хүү нь ямар орчин, нөхцөлд юу сурдаг вэ гэдгийг таниулах үүднээс нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион явуулдаг. Үүгээр ч тогтохгүй ерөнхий боловсролын сургуулийн сурагч нарыг энэ арга хэмжээнд урьж оролцуулдаг. Энэ жил цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж энэхүү үйл ажиллагаа маань харьцангуй хожуу зохион байгуулагдаж байна. "Цэргийн нэг өдөр" арга хэмжээ нь хүүхэд залуучуудад цэрэг, эх оронч үзлийг таниулах, Зэвсэгт хүчнийхээ анги, байгууллагыг сурталчлах ач холбогдолтой. Өнөөдөр тодорхой тооны алба хаагчдын маань ар гэрийн төлөөлөл, зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон хүндэт зочид, төлөөлөгч нар маань хүрэлцэн ирсэн байна. Цэрэг татлагаар олон залуучууд ирдэг. Тэдгээрийг нэгтгэж, нэг зангидсан гар шиг хамт олон болгох нь бидний үүрэг юм" гэсэн бол ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын

Үүний дараа Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид урлагийн үзүүлбэр, жагсаалын болон гардан тулааны хэсэгчилсэн тоглолтоос толилууллаа. Мөн энэ үеэр хугацаат цэргийн алба хаагчдын эцэг, эхчүүдэд ангийн болон алба, салбаруудын үйл ажиллагааг танилцуулах үүднээс ангийн штаб, цэргийн гал тогоо, ахуйн үйлчилгээний төв, салбаруудын цэргийн байр, төрийн ёслолын хувцас, хэрэглэлийг нэг бүрчлэн танилцуулж Батлан хамгаалах салбарт шинээр хэрэглэгдэх зэвсэглэл, цэргийн техникийн үзэсгэлэнг зохион байгууллаа.

Харин өдөрлөгийн төгсгөлд эцэг, эхчүүдийн сэтгэгдэл, санал хүсэлтийг авч хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчдөд дурсамж хадгалуулах ёллолын үйл ажиллагаа болсон юм. Энэ үеэр эцэг, эхчүүд ч мөн адил "Цэргийн нэг өдөр" өдөрлөгийн талаар сэтгэгдэл өндөр байгаа талаараа уламжилж байлаа.


ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
Өдөр: +9	Шөнө: -2
ӨМНӨД СУДАН	
Өдөр: +38	Шөнө: +24
АФГАНИСТАН	
Өдөр: +19	Шөнө: +7

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.357.00	3.417.00
CNY	433.30	436.70
RUB	36.40	38.00
JPY	25.74	26.24
KRW	2.46	2.60

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 28
2021.04.09.
/БААСАН ГАРАГ/
ХАВРЫН ДУНД ЦАГААЧИН ТУУЛАЙ САРЫН НИЙМАН ЦАГААН УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР
Үс засуулбал:
Хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх:
06.15-19.33
Барилдлага:
Түлэх
Шүтэн барилдлага:
Нэр өнгө
Суудал:
Огторгуй.

Аргын тооллын 4 дүгээр сарын 9, Сугар гараг. Билгийн тооллын 28, Шувуун хошуут одтой, улаачин гахай өдөр. Өдрийн наран 6 цаг 15 минутад мандан, 19 цаг 33 минутад жаргана. Тухайн өдөр хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг ирүүлэх, гэм буруутныг шийтгэх, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаа гаргах, сэтгэлд сэтгэй газар очих, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одоосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



хүн-гоор агаар салхинд гарах нь нээлттэй. Нийтийн тээвэр цагийн хязгаарлалттайгаар зөвшөөрөгдсөн салбарынханд үйлчлэх бөгөөд автомашины хөдөлгөөнийг хязгаарлана. Иргэд амны хаалтаа зүүх, хүн хоорондын зай барих зэргээр халдвар хамгааллын дэглэмээ мөрдөж байхыг

авах боломжийг ч бүрдүүлээд байна. Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс 2021 оны 5 дугаар сарын 1-ний дотор нийслэлийн насанд хүрсэн бүх хүнийг дархлаажуулалтад хамруулахыг зорьж байна.

Эх сурвалж: Засаг.мн

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
12780+554	8140+372	22+1

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНӨЛӨГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
1573+14	568+14	1290

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 132,046,206
Эдгэрсэн	Нийт: 107,787,566
Нас барсан	Нийт: 2,867,242

ҮЙЛ ЯВДАЛ

**ХУУЛИЙН ОФИЦЕРУУД
ЗАХИРГААНЫ БОЛОН АЖ АХУЙН
АЖИЛД “ДАРАГДАХ ЁСГҮЙ”-Г
АНХААРУУЛАВ**



ЗХЖШ-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн хуралдааны шийдвэртэй холбогдуулан ЗХЖШ-ын Захиргааны удирдлагын хэлтсээс Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагчийн орлогч болон хуулийн офицеруудтай өчигдөр цахимгаар хуралдлаа.

Цахим хуралд Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Г.Энхболд, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын орлогч, хэлтсийн дарга, хурандаа Д.Ариунболд, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, ЗХЖШ-ын даргын даалгавар гүйцэтгэгч, хурандаа Д.Номт, тус хэлтсийн Хуулийн зөвлөх-ахлах мэргэжилтэн, ахмад А.Эрдэнэманх болон бусад албаны хүмүүс оролцсон юм.

Хурлын эхэнд хурандаа Д.Номт Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдах, ямар нэгэн хэрэг, зөрчил гаргахгүй байхад хуулийн офицеруудын үүрэг, оролцоо асар их гэдгийг онцлоод хууль тогтоомж, албан даалгавар, заавар, зөвлөмжийг бие бүрэлдэхүүнээр судлуулах, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг даалгалаа. Мөн тэрээр дээд шатны болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн хариутай албан бичгийн

шийдвэрлэлтэд анхаарч, ангийнхаа тасаг, албадын ажлын уялдаа, харилцан ажиллагааг сайжруулахад анхаарахыг захисан юм.

Хурандаа Г.Энхболд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний сүүлийн үеийн эрх зүйн шинэчлэл, түүний ач холбогдлын талаар мэдээлэл хүргээд хуулийн офицеруудыг анги, хамт олныхоо хууль ёсны эрхийг хамгаалах, аливаа үйл ажиллагаа, шийдвэрийг хуулийн хүрээнд явуулахад анхаарахаас биш захиргааны болон аж ахуйн ажилд “дарагдахгүй” байхыг онцлов. Үргэлжлүүлэн хурандаа Д.Ариунболд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн удирдлага, штабаас салаа, салбарын захирагч нарт чиглэсэн ажил арга хэмжээг зохион байгуулах, цэргийн албаны харилцаанд хууль тогтоомж, цэргийн дүрмээр тогтоогдсон эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болголоо. Тэрээр төгсгөлд нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хөдөлмөрийн аюулгүй байдал, ахуйн хүрээний зөрчил, цэргийн алба, сахилгын зөрчил, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдынхаа талаарх мэдээллийг сар бүр ирүүлж байх, бие бүрэлдэхүүнийхээ хуулийн мэдлэгийг дээшлүүлэхэд шинэ арга барилаар үр бүтээлтэй ажиллахыг даалгасан юм.

ЦАХИМ ШУУДАНД

**УУЛЧИН ДАЙЧИД ШИНЭ ХӨГЖМИЙН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖТЭЙ БОЛОВ**

Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газраас Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн бие бүрэлдэхүүнд шинэ хөгжмийн тоног төхөөрөмж гардуулан өглөө. Аймгийн ЗДТГ-ын зүгээс тус ангийн иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, ангийн урлаг соёлыг хөгжүүлэхэд дэмжлэг болох үүднээс эдгээрийг өгч байгаа бөгөөд үүнд цахилгаан бөмбөр, өсгөгч, гитар, даралтат хөгжим, утасгүй микрофон зэрэг 9 сая төгрөгийн үнэ бүхий хөгжмийн эд хэрэгсэл багтжээ.

Тоног төхөөрөмжийг Баян-Өлгий аймгийн Засаг дарга Д.Бауыржан, Сагсай сумын Засаг дарга А.Исатай нар гардуулж иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэн эрхэм үйлсэд нь амжилт хүслээ. Мөн Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагч, хурандаа Ц.Буянтогтох “Өнгөрсөн хугацаанд аймаг, сумын ЗДТГ болон Цэргийн штабтай хамтран хуулиар хүлээсэн үүргийн дагуу



гамшиг ослын хор уршгийг арилгахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Цаашид ч хамтран төсөл, төлөвлөгөө

хэрэгжүүлэн, нутаг орныг хөгжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэн ажиллана” гэв.

**ХӨВГҮҮД МААНЬ ЦОГ ЖАВХААТАЙ СҮРХИЙ
ЦЭРГҮҮД БОЛЖЭЭ**



Зэвсэгт хүчний 014 дугаар анги цар тахлын халдварын нөхцөл байдлаас хамааран үр хүүхдүүдээ эргэж чадахгүй байгаа эцэг, эхүүдийг утсан холбоо болон интернетээр дамжуулан “уулзуулж” байна. Тухайлбал, Улаанбаатар хот болон Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь аймгуудаас татагдсан хугацаат албаны дайчдаа ар гэрийнхэнтэй нь холбох ажлыг зохион байгууллаа.

Мөн Зэвсэгт хүчний 167, 256 дугаар ангиуд Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран энэхүү арга хэмжээг явуулсан байна. Ар гэрийнхний зүгээс “Цар тахал голомтлон тархаж байгаа энэ үед хүүхдүүдээ эргэж тойрно гэдэг маш том эрсдэл. Энэ эрсдэлийг тооцож, биднийг үр хүүхдүүдтэй минь цахимгаар холбох ажлыг тогтмол зохион байгуулж байгаа цэргийнхэндээ баярлалаа. Хөвгүүд маань цог жавхаатай сүрхий цэргүүд болжээ” хэмээн талархал дэвшүүлжээ.

МАНАЙХ “НИСЭХИЙН АЙЛ” ГЭДГЭЭР ОВОГЛОЖ ЯВДАГ

Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Тус ангиас БНМАУ, ЗХУ-ын баатар, сансрын нисэгч 1, Монгол Улсын Гавьяат нисэгч 7, Гавьяат техникч 1 тус тус төрөн гарсан байдаг. Ангийн хамт олны бахархал болсон эдгээр алдартны нэг Монгол Улсын Гавьяат техникч, бэлтгэл дэд хурандаа Ч.Цэрэндорж гуайтай уулзаж ярилцлаа.

Нисэхтэй холбогдсон түүхээс тань ярилцлагаа эхлээ?

-Амрыг эрье. Би 1966 онд Ардын Армийн 109 дүгээр ангийг анх тулгаа тулж байх үеэс моторчноор ажиллаж эхэлсэн. Улмаар 1968 онд Краснодар хотын Цэргийн нисэхийн дунд сургуулийн нисэгчийн ангид шалгалт өгсөн боловч эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй. Харин техникчийн ангид нь тэнцэж тэрхүү нэр хүндтэй сургуульд суралцах боломж олдсон. 1970 онд сургуулиа төгсөж ирээд 1999 он хүртэл энэ ангидаа ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан даа.

Гэр бүлийнхээ талаар товч танилцуулбал?

-Сайхан хантайгаа 1971 онд нисэхэд танилцаж байлаа. Дараа жил нь бид хоёр гэр бүл болж анхны хүүхдээ өлгийдөн авсан. Хоёр сайхан охинтой, ам бүл 4-үүллээ өнөр өтгөн аз жаргалтай, сайхан амьдарч байна. Охид маань айлын бэр болцгоож үр хүүхдүүдтэйгээ амьдарч байна. Манай хүргэд нисэхэд ажилладаг. Манайхыг “нисэхийн айл” гэгцээдэг юм. Нисэх бол их өндөр босготой, хүний амьдрал ахуйд өгөөжөө өгсөн сайхан газар даа.

Таны мэргэжлийн бахархал?

-Уг нь нисэгч болъё гэж бодож зорьсон. Манай ах Рэгэнгийн Ренчин гэж маш сайн нисэгч байсан. Ахынхаа мэргэжлийг эзэмших гэтэл эрүүл мэндээр тэнцээгүй.

Тэгээд техникч мэргэжил эзэмшээд, нисдэг тэрэг, онгоцон дээр ажиллаж ер нь техникийн талын бүх юмыг эзэмшиж ажилласан. Улмаар техникийн мэдлэг, чадвар маань үргэлж өсөж ялангуяа нислэгт явах гэж байгаа нисдэг тэрэг, онгоцонд үзлэг хийж нислэгийн өмнөх бэлтгэлийг сайн хийж байсан. Ер нь нисэхийн инженер, техникийн бүрэлдэхүүн, инженер гэсэн мэргэжил эзэмшсэн хүн бүр ер нь бүх юмыг засдаг, үйлчилгээ үзүүлэх чадвартай байдаг. Тэгээд ч машин, техник, онгоц, нисдэг тэрэг бүхий л техникүүд нэгдсэн нэг онол, технологиор бүтээгдсэн байдаг учир хөрвөх боломжтой сайхан мэргэжил гэж бодож явдаг даа.

Та мэргэжлээрээ хэдэн жил ажиллав?

-Тухайн үеийн нэршлээр Монголын Ардын Армийн нисэх хүчинд 1966-1999 он хүртэл нийтдээ 33 жил одоогийн Зэвсэгт хүчний 303 дугаар ангид ажилласан. Улмаар 1999 онд гавьяаныхаа амралтад гараад агаарын тээврийн “Синтраль Монголия Эйрвэсс” компанид 2018 он хүртэл ажилласнаар Монголын нисэх хүчинд нийтдээ 52 жил хүчин зүтгэсэн байна.

Сэтгэлд хүногшсон дурсамжаа хуваалцана уу?

-Нисэх экипажид борт механикч гэсэн албан тушаалд томилогдон МИ-8 нисдэг тэрэг, МИ-8МТВ-1, АН-24 нисдэг тэрэг, онгоцнуудад нисэж байсан. Нислэгт явахад борт механикчийн үүрэг онцгой их. Тодруулбал, бүх эд ангийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангаж, хянаж явдаг.

Нислэгийн үеэр тохиолдсон хүнд хэцүү зүйлүүд их л гардаг байлаа. Түүрүү үеийн МИ-8 нисдэг тэрэгт локатор байхгүй, үүлэнд орчих юм бол цахилгаан, аадар бороо, уул бүх юмыг харах нүдгүй л болно гэсэн үг. Энэ үед нисгэгчдээс өндөр ур



чадвар, мэдрэмж гаргаж маш тооцотой нисэхийг шаарддаг юм.

Хэр олон гарын шавтай бэ?

-1972 онд МИ-8 нисдэг тэрэгний борт механикч болсноос хойш нисдэг тэрэгний мэргэжилтэй боловсон хүчнийг хуучнаар ЗХУ-д бэлтгэдэг байлаа. Тэр үед Монголын Ардын Арми нисээд олон нисдэг тэрэгтэй болсон тул мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай болж эхэлсэн. Ингээд 1982 онд Гавьяат нисэгч Н.Пүрэвсүрэнтэй хамтран “МИ-8” нисдэг тэрэгний нисгэгч, техникчдийг дотооддоо бэлтгэх курс зохион байгуулах тухай санал тавьсан. БХЯ энэ саналыг нааштай хүлээн авснаар 1982 онд анх “АН-2” онгоцны нисгэгчдийг бэлтгэсэн. Техникийг цэргийн албанаас болон хугацаат цэргийн алба хаагчдаас сонгон авч сургааснаар анх удаа 17 нисгэгч, техникийг дотоодын курсээр бэлтгэсэн юм. Тэр үед 3 сарын хугацаатай бэлтгэж байлаа. Түүний дараа 1982, 1984 онд дахин курс хичээллүүлж 30 гаруй хүнийг төгсгөсөн. Анхны бэлтгэсэн шавь нар маань бүгд гавьяаныхаа амралтад гарчээ. Одоо ажиллаж байгаа миний гарын шавь гэвэл хэдхэн л хүн байна даа.

Залуу, хойч үеийнхэндээ хандаж юу хэлэх вэ?

-Ер нь инженерийн мэргэжлийг эзэмшсэн хүн тэрүүгээрээ дагнан ажиллаж мэргэжлийнхээ ур чадварыг үргэлж дээшлүүлэн, ямарваа нэгэн гэнэтийн аюул болоход яаралгүй, тэвдэлгүй, овсгоотой, үр чадвар, авхаалж самбаатай ажиллаж аюулаас өөрийгөө болон нөхрийгөө авч гардаг. Мөн аливаа юмыг байнга үзэж судалж байвал хүний оюун ухаан, сэтгэн бодох чадвар тэр хэрээрээ дээшилдэг. Ялангуяа инженер, техникийн бүрэлдэхүүн ахлагчдад эд ангиудыг задалж сэтгэн бодох ур чадвараа дээшлүүлэх талаар анхаарч байвал зохино. Миний хувьд машин техник, онгоц, нисдэг тэрэгний эд ангиудыг оролдох, задалж үзэх дуртай. Залуучууд маань үүнд суралцаж, хүний үгийг сайн сонсож байх хэрэгтэй.

Ахлах дэслэгч Г.БИЛГҮҮТЭЙ

ТАНЫ СОНОРТ

МӨНХИЙН БЕСТСЕЛЛЕР

FranklinCovey EDUCATION MONGOLIA

Монгол хүн 3030 сан

7 дадлын Гайхамшиг

Дэлхийг Гэрэлтүүлнэ

ЭЦЭГ, ХҮҮ КОВИ НАРЫН БҮТЭЭЛЭЭС

Стефен Р.Кови, Стефен М.Р.Кови, Шонн Кови

Холбоо барих: 89002329, 70140100 | info@franklincovey.mn

FranklinCovey Mongolia | franklincovey.com, www.theleaderinme.org

СОЁМБО СОНИН

“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАЛАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхний “Соёмбо” сонины редакцияд бэлтгэж, “Соёмбо принтинг” хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламны хямд нийтлэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029